APT40 Зөвлөмж

БНХАУ-ын Төрийн Аюулгүй Байдлын Яам (MSS)-ын тагнуулын аргачлалын хэрэгжилт

Australian Government

Australian Signals Directorate

National Cyber
Security Centre
a part of GCHQ

Communications
Security Establishment

**Canadian Centre
for Cyber Security**

Centre de la sécurité
des télécommunications

**Centre canadien
pour la cybersécurité**

ГАРЧИГ

Тойм

Ерөнхий мэдээлэл

Мэдээлэл технологийн аюулгүй байдлын энэхүү зөвлөмжийг дараах байгууллагууд хамтран боловсруулсан болно. Үүнд: Австралийн Холбооны Дохиоллын Газрын (ASD) дэргэдэх Австралийн Цахим Аюулгүй Байдлын Төв (ACSC), АНУ-ын Цахим аюулгүй байдал, Дэд бүтцийн аюулгүй байдлын агентлаг (CISA), Үндэсний Аюулгүй Байдлын Агентлаг (NSA), Холбооны Мөрдөх Товчоо (FBI), Их Британийн Үндэсний Цахим Аюулгүй Байдлын Төв (NCSC-UK), Канадын Цахим Аюулгүй Байдлын Төв (CCCS), Шинэ Зеландын Үндэсний Цахим Аюулгүй Байдлын Төв (NCSC-NZ), Германы Холбооны Тагнуулын Алба (BND) болон Үндсэн хуулийг хамгаалах холбооны газар (BfV), БНСУ-ын Үндэсний Тагнуулын Алба (NIS) болон NIS-ийн харьяа Цахим Аюулгүй Байдлын Үндэсний Төв, Японы Цахим Халдлагад Бэлэн Байдлыг Хангах, Стратеги Боловсруулах Үндэсний Төв (NISC) болон Үндэсний Цагдаагийн Агентлаг (NPA) багтана. Эдгээр байгууллагуудыг цаашид "зохиогч агентлагууд" гэж нэрлэнэ. Энэхүү зөвлөмжид Бүгд Найрамдах Хятад Ард Улсын (БНХАУ) төрийн дэмжлэгтэй цахим бүлэглэл болон тэдгээрийн Австралийн сүлжээнд учруулж буй одоогийн аюулыг тусгасан болно. Энэхүү зөвлөмжийг нийтэлсэн агентлагуудын цахим аюулын талаарх хамтарсан ойлголт болон цахим халдлагын ASD-ийн ACSC-ээс хийсэн хариу арга хэмжээний судалгаанд тулгуурлан бүтээв.

БНХАУ-ын төрөөс дэмжлэг авсан цахим бүлэглэл өмнө нь Австрали, АНУ зэрэг олон улсын байгууллагуудыг чиглэсэн дайралт хийж байсан бөгөөд доорх арга техникүүдийг дэлхий даяар бусад БНХАУ-ын төрийн ивээл дор үйл ажиллагаа явуулдаг цахим бүлэглэлүүд тогтмол ашигладаг. Иймд эдгээр бүлэглэл болон ашиглагдаж буй техник, арга барил нь зохиогч агентлагуудын улс орны сүлжээнд мөн адил аюул учруулж байгаа хэмээн дүгнэж байна.

Зохиогч агентлагууд энэхүү бүлэглэлийг БНХАУ-ын Төрийн Аюулгүй Байдлын Яам (MSS)-ны удирдлага дор хорлон сүйтгэх цахим ажиллагаа явуулдаг гэж дүгнэж байна. Тэдний үйл ажиллагаа, ашиглаж буй арга техник нь салбарын тайлангууд дээрх Kryptonite Panda, GINGHAM TYPHOON, Leviathan, Bronze Mohawk гэх нэрээр бүртгэгдсэн Advanced Persistent Threat буюу APT40 бүлэгтэй ижил байгаа юм. Энэхүү бүлэглэлийг өмнө нь Хайнань мужийн Хайкоу хотод төвтэй бөгөөд Хятадын Төрийн Аюулгүй Байдлын Яамны тус хот дахь салбараас үүрэг, даалгавар авдаг гэж мэдээлж байсан.[2] Дараах зөвлөмжид халдлагын арга техникүүдийг хоёр хохирогчийн сүлжээнд хэрхэн хэрэгжүүлсэнийг харуулах онцлох жишиг судалгааны жишээг өгүүлнэ. Эдгээр жишиг судалгаанууд нь цахим аюулгүй байдлын мэргэжилтнүүдэд өөрсдийн сүлжээг APT40 бүлэглэлийн халдлагаас хамгаалах, халдлагыг илрүүлэх болон сэргээн засварлах үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой юм. Сонгогдсон жишиг судалгаанууд нь халдлагад өртсөн байгууллагууд зохих хариу арга хэмжээг авч, дахин халдлагад өртөх эрсдэлийг бууруулсан тохиолдлууд юм. Ийм учраас эдгээр жишээнүүд нь харьцангуй хуучны үйл явдлууд бөгөөд холбогдох байгууллагуудад хамгаалалтын арга хэмжээ авах, хэрэгжүүлэх хангалттай хугацаа байсан гэж үзэж болно.

Үйл ажиллагааны хураангуй

APT40 бүлэглэл Австралийн сүлжээнүүд болон бүс нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын сүлжээг удаа дараа онилж ирсэн бөгөөд тэдний учруулж буй аюул одоог хүртэл үргэлжилсээр байна. Энэхүү зөвлөмжид дурдсан арга барилыг Австралийн сүлжээнүүдэд халдлага хийхэд байнга ашиглаж байгаа нь ажиглагдсан.

Тухайлбал, APT40 бүлэг нь шинэ аюулгүй байдлын сул талыг илрүүлэх туршилтын загварыг (POC) богино хугацаанд боловсруулж, холбогдох сул тал бүхий дэд бүтэцтэй сүлжээнд шууд ашиглан халдах чадвартай. APT40 бүлэг халдлага хийх боломжийг эрэлхийлэн, энэхүү зөвлөмжийг хамтран гаргасан агентлагуудын төрийн мэдлийн сүлжээг болон бусад зорилтот сүлжээнүүдэд тогтмол тандалт хийдэг. Энэхүү тогтмол тандалтаар зорилтот сүлжээнүүдийн хамгаалалтгүй, ашиглалтаас гарсан буюу засвар үйлчилгээ хийгдээгүй төхөөрөмжүүдийг илрүүлж, шуурхай сул талыг ашиглах нөхцөл бүрдүүлдэг. APT40 бүлэг 2017 оноос хойш програм хангамжийн сул талыг ашиглан амжилттай халдлага хийсээр байна.

Энэ бүлэглэл нь Log4J (CVE-2021-44228), Atlassian Confluence (CVE-2021-31207, CVE-2021-26084) болон Microsoft Exchange (CVE-2021-31207; CVE-2021-34523; CVE-2021-34473) зэрэг өргөн хэрэглэгддэг програм хангамжуудад шинээр илэрсэн сул талыг маш богино хугацаанд ашиглан халдлага хийдэг. ASD-ийн ACSC болон бусад зохиогч агентлагуудын таамаглаж буйгаар, уг бүлэглэл цаашид ч шинээр олон нийтэд танилцуулах программын сул талыг хэдхэн цаг, өдрийн дотор POC-уудаа (proof-of-concept) ашиглан хурдан хугацаанд халдлага явуулах төлөвтэй байна.

2 АНУ-ын Хууль Зүйн Яам. 2021. Төрийн Аюулгүй Байдлын Яамтай хамтран ажиллаж байсан Хятад улсын дөрвөн иргэнийг халдварт өвчний судалгаанаас эхлээд оюуны өмчийн болон бизнесийн нууц мэдээлэл рүү чиглэсэн олон улсын цахим халдлагын үйл ажиллагаандоролцсон гэх үндэслэлээр буруутган ял оноожээ.

Зураг 1: APT40 үйл ажиллагааны TTP урсгал диаграм



Энэ бүлэглэл нь хэрэглэгчийн оролцоо шаардсан фишинг зэрэг арга техникийг ашиглахаас илүүтэй, ил тод, интернэтэд нээлттэй байрласан эмзэг дэд бүтцэд шууд халдахыг илүүд үздэг. Мөн тэд хууль ёсны нэвтрэх эрх (нууц үг, итгэмжлэл) олж авахыг маш чухалчилдаг ба энэ нь дараагийн олон төрлийн халдлагыг гүйцэтгэх үндэс суурь болдог. APT40 бүлэглэл нь тогтвортой нэвтрэх орчныг бий болгохын тулд ялангуяа халдлагын эхний шатанд тогтмол арын хаалга буюу “web shell”-г ашигладаг (T1505.003). Ерөнхийдөө, анхны нэвтрэлт амжилттай болсны дараа APT40 бүлэг тогтмол нэвтрэхийг зорьдог. Гэвч тогтмол нэвтрэлт (persistence) ихэвчлэн халдлагын эхэн үед явагддаг учраас энэ нь халдлагын цар хүрээ, дараагийн үйлдлүүдээс үл хамааран бараг бүх халдлага дээр илэрдэг.

Онцлох арга барил

APT40 нь өмнө нь Австралийн вебсайтууд руу халдаж, үйл ажиллагаандаа команд ба хяналтын (C2) хост болгон ашиглаж байсан ч, энэ техникээ өөрчилж сайжруулсан байна (T1594).

APT40 бүлэглэл нь сүүлийн үед дэлхий даяар ажиглагдаж буй чиг хандлагыг даган, жижиг оффис/гэрийн хэрэглээний төхөөрөмжүүдийг (SOHO – small-office/home-office devices) үйл ажиллагааны дэд бүтэц болон сүүлчийн дамжуулагч (last-hop redirector) болгон ашиглах болсон бөгөөд энэ нь Австрали дахь халдлагад мөн хамаарна (T1584.008).

Энэхүү арга барил нь зохиогч агентлагуудын хувьд APT40 бүлэглэлийн үйл ажиллагааг илүү нарийвчлан шинжилж, хянах боломжийг бүрдүүлсэн.

Ийм төрлийн SOHO (жижиг оффис/гэрийн хэрэглээний) төхөөрөмжүүд нь ихэвчлэн ашиглалтын хугацаа нь дууссан эсвэл шинэчлэлт хийгдээгүй байдаг тул N-day төрлийн хялбар бай болдог. Нэгэнт халдлагад өртсөн тохиолдолд, эдгээр төхөөрөмжүүд нь хууль ёсны сүлжээний урсгалыг дуурайлгах замаар халдлага эхлүүлэх цэг болж, сүлжээний хамгаалалтын системүүдийг төөрөгдүүлж, илрэхгүй байх нөхцөл бүрдүүлдэг (T1001.003).

Энэ техникийг зөвхөн APT40 биш, БНХАУ-ын төрийн дэмжлэгтэй бусад олон цахим бүлэглэлүүд дэлхий даяар тогтмол ашиглаж байгаа бөгөөд зохиогч агентлагууд энэ аргыг нийтлэг аюул гэж үзэж байна. Нэмэлт мэдээллийг дараах хамтарсан зөвлөмжөөс үзнэ үү: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн дэмжлэгтэй цахим бүлэглэлүүд сүлжээний үйлчилгээ үзүүлэгчид болон төхөөрөмжүүдийг ашиглаж буй талаар болон БНХАУ-ын төрийн дэмжлэгтэй бүлэглэлүүд АНУ-ын стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцэд халдан, урт хугацаанд хандалтаа хадгалсан тухай.

APT40 бүлэглэл зарим тохиолдолд худалдан авсан буюу түрээслэсэн дэд бүтцээ хохирогч руу чиглэсэн C2 дэд бүтэц болгон ашигладаг. Гэвч, энэ арга барил нь харьцангуй цөөрөх хандлагатай байна.

Арга хэрэгслүүд

ASD-ийн дэргэдэх ACSC нь доорх мөрдөн шалгалтуудаар илэрсэн хортой файлуудын заримыг олон нийтэд дэлгэж байна. Эдгээр файлуудыг VirusTotal платформд байршуулснаар сүлжээний хамгаалалт болон цахим аюулгүй байдлын мэргэжилтнүүд тухайн аюул заналхийллийг илүү нарийвчлан судалж, үр дүнтэй хамгаалах арга хэмжээг цаг алдалгүй авах боломжтой болсон.

Жишиг судалгаа

ASD-ийн Цахим Аюулгүй Байдлын Төв (ACSC) нь уг бүлэглэл хэрхэн өөрсдийн хэрэгсэл, арга барилыг ашигладаг талаар мэдлэг олгох зорилгоор дараах хоёр нэрийг нь нууцалсан судалгаа, мөрдөн шалгалтын тайланг хуваалцаж байна.

MD5	Файлын нэр	Нэмэлт мэдээлэл
26a5a7e71a601be991073c78d513dee3	horizon.jsp	1 kB | Java Source
87c88f06a7464db2534bc78ec2b915de	Index_jsp$ProxyEndpoint$Attach.class	597 B | Java Bytecode
6a9bc68c9bc5cefaf1880ae6ffb1d0ca	Index_jsp.class	5 kB | Java Bytecode
64454645a9a21510226ab29e01e76d39	Index_jsp.java	5 kB | Java Source
e2175f91ce3da2e8d46b0639e941e13f	Index_jsp$ProxyEndpoint.class	4 kB | Java Bytecode
9f89f069466b8b5c9bf25c9374a4daf8	Index_jsp$ProxyEndpoint$1.class	3 kB | Java Bytecode
187d6f2ed2c80f805461d9119a5878ac	Index_jsp$ProxyEndpoint$2.class	1 kB | Java Bytecode
ed7178cec90ed21644e669378b3a97ec	Nova_jsp.class	7 kB | Java Bytecode
5bf7560d0a638e34035f85cd3788e258	Nova_jsp$TomcatListenerMemShellFromThread.class	8 kB | Java Bytecode
e02be0dc614523ddd7a28c9e9d500cff	Nova_jsp.java	15 kB | Java Source

Жишиг судалгаа 1

Энэхүү тайланг олон нийтэд илүү түгээх үүднээс нэр, байгууллагын мэдээллийг нууцалсан болно. Халдлагад өртсөн байгууллагыг цаашид "байгууллага" гэж нэрлэнэ. Хохирогч байгууллага болон ASD-ийн ACSC-ийн хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний аргачлалыг нууцлах зорилгоор зарим нарийн мэдээллийг хассан болно.

Товч хураангуй

Энэхүү тайланд ASD-ийн Цахим Аюулгүй Байдлын Төв (ACSC)-ийн 2022 оны долоодугаар сараас есдүгээр сарын хооронд байгууллагын сүлжээнд амжилттай халдсан тохиолдлын мөрдөн шалгалтын үр дүнг тусгасан болно. Мөрдөн шалгалтын энэхүү тайланг байгууллагад хүргүүлсэн бөгөөд илэрсэн халдлагын үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж, хамгаалалт, сэргээлтийн зөвлөмжийг хүргэсэн болно. Мөрдөн шалгалтын үр дүнд энэхүү халдлагыг APT40 бүлэглэл үйлдсэн болохыг тогтоосон.

2022 оны наймдугаар сарын дунд үед ASD-ийн ACSC нь тус байгууллагын сүлжээнд APT40 бүлгийн явуулсан сэжигтэй үйл ажиллагааг илрүүлж, үүний талаар мэдэгдсэн. Байгууллагын зөвшөөрлийн дагуу, ACSC нь хариу арга хэмжээний хүрээнд халдлагад өртсөн байж болзошгүй төхөөрөмжүүд дээр хост суурьтай мэдрэгч (host-based sensor) суурилуулсан. Эдгээр сенсоруудын тусламжтайгаар ASD-ийн ACSC-ийн шинжээчдэд нарийвчилсан дижитал шинжилгээ (digital forensics) хийх боломжтой болсон. Мэдээлэл цуглуулах мэдрэгчүүдийн өгөгдөлд үндэслэн, ACSC-ийн шинжээчид халдлагын бүлэглэлийн үйл ажиллагааг амжилттай тодорхойлж, болсон үйл явдлуудын дэлгэрэнгүй цаг хугацааны дарааллыг гаргажээ.

2022 оны 7-8 саруудад ACSC-ийн ACSC дараах гол үйл ажиллагааг илрүүлсэн:

- Хост тандан судалгаа (host enumeration): Халдагч сүлжээний бүтцийн зураглалыг гаргах;
- Арын хаалга (web shell) ашиглалт: Сүлжээнд анхны хандалт үүсгэх ба командыг зайнаас гүйцэтгэх боломж олгодог;
- Бусад хортой хэрэгслийн байршуулалт: Халдлага хийх зорилгоор тусгай програмууд ашиглах.

Шалгалтын явцад тухайн бүлэглэл, их хэмжээний хувийн мэдээлэлд нэвтэрсэн, мөн сүлжээгээр дотоод (lateral movement) шилжилт хийх байдлаар мэдээлэл хулгайлсан (T1021.002) ул мөр , нотолгоонууд илэрсэн. Халдлагын ихэнх хэсгийг бүлэглэл сүлжээнд нэвтрэх олон суваг (access vectors) бий болгосон, сүлжээ нь "flat" буюу хэсэгчлээгүй бүтэцтэй байсан, мөн дур мэдэн файл байршуулж болох хамгаалалтгүй дотооддоо хөгжүүлсэн програм хангамж ашигласан зэрэг нөхцлүүд бүрдсэн байдалтай холбон тайлбарлаж болно. Гадагш зөөвөрлөгдсөн мэдээлэлд бүлэглэлд сүлжээнд нэвтрэх боломж олгосон эрх бүхий баталгаажуулалтын бүртгэлийн мэдээлэл, мөн анхны нэвтрэх суваг хаагдсан тохиолдолд дахин зөвшөөрөлгүй нэвтрэхэд ашиглаж болох сүлжээний бүтцийн мэдээлэл багтаж байв. Хамгийн анх халдлагад өртсөн төхөөрөмжөөс өөр хортой хэрэгсэл илрээгүй боловч тус бүлэг нь хууль ёсны, эрх бүхий бүртгэлийн мэдээлэлд нэвтрэх боломжтой байсан нь цаашид тусгай хэрэгсэл ашиглах шаардлагагүй болгож байв. Мөрдөн шалгалтын үр дүнгээс үзэхэд, уг байгууллага нийтэд ил болсон программ хангамжын сул талд санамсаргүйгээр өртсөн бус, харин APT40 бүлэглэлийн санаатайгаар бай болгосон, зорилтот халдлагын золиос болсон нь тогтоогдсон байна.

Мөрдөн шалгалтын үр дүн

2022 оны наймдугаар сарын дунд үед, ASD-ийн Цахим Аюулгүй Байдлын Төв (ACSC) тухайн байгууллагад хандан, долдугаар сараас наймдугаар сар хүртэл тус байгууллагын компьютерийн сүлжээнд улсын санхүүжилттэй хакерын бүлэгтэй холбоотой батлагдсан нэгэн хортой IP хаяг холбогдсон тухай мэдээлсэн. Халдлагад өртсөн төхөөрөмж нь магадгүй жижиг бизнес эсвэл хувь хэрэглэгчид харьяалагддаг байсан байх өндөр магадлалтай.

Наймдугаар сарын сүүл үед, ASD-ийн Цахим Аюулгүй Байдлын Төв (ACSC) тухайн байгууллагын сүлжээнд хост дээр суурилсан програм суурилуулсан ба үүний үр дүнд халдлагад өртсөнийг илрүүлж чадсан.

Мөрдлөгийн ажиллагаанд тус болох байсан зарим эд мөрийн баримтууд нь лог бүртгэлийн тохиргоо эсвэл сүлжээний бүтцийн онцлогоос шалтгаалан ашиглах боломжгүй байсан. Гэсэн хэдий ч байгууллагаас боломжтой бүх мэдээллийг бүрэн, шуурхай гаргаж өгсөн нь ASD-ийн ACSC-ийн шинжээчдэд нарийвчилсан дүн шинжилгээ хийх боломж олгож, APT40 бүлгийн сүлжээнд явуулсан үйл ажиллагааны талаар бодит ойлголт авахад чухал хувь нэмэр болсон.

Есдүгээр сард, ASD-ийн ACSC-тэй зөвлөлдсөний дараа, байгууллага анхлан мэдээлэгдсэн сэжигтэй IP хаягийг хар жагсаалтад (denylist) оруулахаар шийдсэн. Аравдугаар сард, байгууллага алдааг засах буюу сэргээх ажиллагаагаа эхлүүлсэн.

Дэлгэрэнгүй

Долоодугаар сараас эхлэн, халдагч этгээдүүд `<webapp>2-ext` дээр ажиллаж байсан тусгайлан боловсруулсан веб програмыг (T1190) шалгаж, ашиглан сүлжээний DMZ (Сүлжээний Хамгаалалт Сул Бүс) хэсэгт байршуулж чадсан. Энэ боломжийг ашиглан тэд тухайн сүлжээ болон ил харагдаж байсан бүх домэйнүүдийг тоолж, зураглал үүсгэсэн. Хулгайлагдсан нэвтрэх эрхүүдийг (T1078.002) ашиглан Active Directory-с (T1018) мэдээлэл хайж, мөн DMZ доторх хэд хэдэн төхөөрөмжөөс файл хуваалцах протоколыг ашиглан (T1039) мэдээллийг гадагш зөөвөрлөжээ. Халдагч этгээд сүлжээний серверээс хүчинтэй сүлжээний нэвтрэх эрх авах зорилгоор Керберос халдлагыг гүйцэтгэсэн (T1558.003). Цахим халдлага үйлдэгч бүлэглэлийн зүгээс DMZ болон дотоод сүлжээний өөр бусад хэсэгт нэвтэрсэн болох нь ажиглагдаагүй.

Цаг хугацааны дараалал

Доорх цаг хугацааны дараалал нь байгууллагын сүлжээнд ажиглагдсан цахим халдлагын үйл ажиллагааны гол үе шатуудыг ерөнхийд нь харуулж байна.



Нарийвчилсан цаг хугацааны дараалал

Долоодугаар сар: Халдагчид байгууллагад зориулан бүтээсэн веб аппликейшний (T1190) (цаашид “вэб програм” эсвэл “*webapp*” гэх) нүүр хуудсанд анхны холболтоо тогтоосон. Энэ үйлдэл нь Transport Layer Security (TLS) холболтоор хийгдсэн (T1102). Бусад анхаарал татахуйц үйл ажиллагаа энэ сард ажиглагдаагүй.

Долдугаар сар: Халдагч этгээдүүд байгууллагын веб аппликейшн рүү чиглэсэн сайтыг шалгаж, цааш судлах боломжтой сүлжээний төгсгөлийг (endpoints) тодорхойлох ажиллагааг эхлүүлэв [2].

Долдугаар сар: Халдагч этгээдүүд тодорхой нэг сүлжээний endpoint рүү чиглэсэн дайралтаа төвлөрүүлэв.

Долдугаар сар: Халдагч этгээдүүд веб сервер рүү амжилттай `POST` хүсэлт илгээж чадсан нь магадгүй өмнө нь өөр хуудас дээр байршуулсан арын хаалга (web shell) ашигласан байх боломжтой. Үүний дараа хоёр дахь IP хаяг мөн л ижил URL рүү хүсэлт илгээж эхэлсэн бөгөөд энэ нь магадгүй ижил халдагч бүлэгтэй холбоотой байх магадлалтай. Халдагч этгээдүүд хэд хэдэн магадлалтай арын хаалга (web shell) үүсгэж, туршсан байна.

Үнэн хэрэгтээ ашигласан арга нь тодорхойгүй боловч тодорхой нэг сүлжээний төгсгөл рүү чиглэсэн файл үүсгэх оролдлого явагдсан нь илэрхий бөгөөд энэ нь `<webapp>2-ext` хаяг дээр хийгдсэн.

ASD-ийн ACSC-ийн үзэж буйгаар дээрх хоёр IP-гийн холболт нь ижил халдлагын хүрээнд хийгдсэн байх өндөр магадлалтай бөгөөд хоорондын холболтууд нь хэдхэн минутын зайтай болсон нь үүнийг нотолж байна.

Долдугаар сар: Энэхүү бүлэглэл үйлдлээ үргэлжлүүлэн хостын мэдээллийг тодорхойлох (host enumeration) ажиллагаа хийж, нэвтрэх эрх нэмэгдүүлэх (privilege escalation) боломж хайж, өөр төрлийн арын хаалга (web shell) байршуулав. Тэд алдагдсан нууц үгээр `<firstname.surname>@<organisation domain>` хаягаар веб аппликейшн рүү нэвтэрчээ.

`<webapp>2-ext` дээр нэвтрэх эрх нэмэгдүүлэх үйлдэл амжилтгүй болсон бололтой. Үүний оронд, халдагч этгээдүүд сүлжээнд суурилсан үйл ажиллагаа руу шилжсэн.

Долдугаар сар: Халдагч этгээдүүд дотоодод нэвтрэх боломжтой хоёртын (binary) файлд хардкод хийгдсэн байх магадлалтай үйлчилгээний хаягт хэрэглэгчийн нэр, нууц үгийг ашиглаж шалгав.[3]

Долдугаар сар: Халдагч этгээдүүд open source хэрэгсэл болох Secure Socket Funnelling (SSF)-г байршуулсан бөгөөд уг хэрэгсэл нь мэдээллийг гадагш хортой дэд бүтэц рүү холбогдоход ашиглагдсан байна. Энэхүү холболтыг ашиглан халдагч талын төхөөрөмжүүдээс байгууллагын дотоод сүлжээнд туннел үүсгэн нэвтрэх оролдлого хийсэн бөгөөд бүртгэлд тухайн төхөөрөмжийн нэрс нь “service account” буюу үйлчилгээний аккаунт ашиглах оролдлогын үед ил болсон.

Наймдугаар сар: Халдагчид хязгаарлагдмал халдлагын ажиллагаа явуулсан бөгөөд үүнд “service account” буюу үйлчилгээний аккаунтыг ашиглан холболт тогтоох гэсэн амжилтгүй оролдлогууд орно.

Наймдугаар сар: Халдагч этгээдүүд сүлжээ болон “Active Directory” буюу удирдлагын системийг өргөн хүрээнд тодорхойлох ажиллагаа явуулсан. Үүний дараа өөр нэг алдагдсан эрхтэй хэрэглэгчийн бүртгэл ашиглан, DMZ-д байрлах [4]Windows төхөөрөмжүүд дээр network share-уудыг холболт хийснээр мэдээлэл гадагш зөөвөрлөгджээ.

Энэ нь DMZ бүсэд хандах боломжтой төхөөрөмжүүд дээр санамсаргүй байдлаар хулгайлагдсан нэвтрэх эрхийн мэдээллийг ашигласан байх магадлалтай. Хамгаалалтын систем (Firewalls) дотоод сүлжээг ижил аргаар онилох оролдлогыг хаасан байна.

Найм – Есдүгээр сар: SSF (Secure Socket Funnelling) хэрэгсэл дахин холбогдож, хортой IP хаяг руу сүлжээний туннел үүсгэсэн. Тухайн бүлэглэл өөр нэмэлт халдлага хийсэн нь нь тогтоогдоогүй бөгөөд тэдний хандалтыг хаах хүртэл идэвхгүй байжээ.

Есдүгээр сар: Байгууллага тухайн хортой IP-г хамгаалалтын систем (Firewalls) дээрээ denylist буюу хориглосон жагсаалтад оруулж блоклосон.

2 Энэ нөхцөлд “endpoint” гэдгийг нь веб аппликейшний функц гэсэн утгаар оруулсан болно.
3 “Service account” гэдэг нь тодорхой хэрэглэгч бус, харин үйлчилгээнд ашиглагддаг хэрэглэгчийн эрх юм. Microsoft домэйн орчинд янз бүрийн төрлийн хэрэглэгчийн бүртгэл байдаг.
4 “Mounting shares” гэдэг нь файл системийн бүтэц дэх файлуудыг хэрэглэгч болон хэрэглэгчийн бүлэгт хандах боломжтой болгох үйлдэл юм.

Халдагчийн ашигласан арга, техникүүд:

MITRE ATT&CK Framework нь цахим орчинд аюул занал учруулагч этгээдүүдийн хэрэглэдэг арга, техникүүдийг бүртгэн баримтжуулсан сан юм. Энэхүү санг АНУ-ын ашгийн төлөө бус байгууллага болох MITRE Corporation боловсруулсан бөгөөд дэлхий дахинд цахим заналхийллийн нийтлэг толь болгон ашигладаг.

ASD-ийн харьяа Цахим Аюулгүй Байдлын Төв (ASD's ACSC) дараах арга, техникүүдийн тухайн халдагч этгээдийн хортой үйл ажиллагаатай холбоотой гэж дүгнэж байна:

Халдлагын талаарх мэдээлэл цуглуулалт

T1594 – Хохирогчийн эзэмшлийн вебсайтыг шүүх

Халдагч тал байгууллагад зориулан бүтээсэн веб аппликейшний сайтын бүтцийг шалгаж, сүлжээнд нэвтрэх боломж хайсан.

Эхний нэвтрэлт

T1190 – Гадагш хандалттай аппликейшнүүдийг ашиглан нэвтрэх (Байгууллагын тусгай веб аппликейшнийг ашигласан үйлдэлтэй холбоотой)

T1078.002 – Хүчин төгөлдөр хэрэглэгчийн хаяг: Домэйн хэрэглэгчийн эрх (Хулгайлагдсан хэрэглэгчийн эрхийг ашиглан системд нэвтэрсэнтэй холбоотой)

Интернэтэд нээлттэй байршуулсан тусгай веб аппликейшнийг ашигласнаар халдагч этгээд сүлжээнд анхны хандалт үүсгэж чадсан. Үүний дараа тэд өмнө нь хулгайлсан нэвтрэх мэдээллүүдийг ашиглан сүлжээнд илүү өргөн хүрээгээр хандах боломжтой болсон.

Гүйцэтгэл

T1059 – Command and Scripting Interpreter программ (Арын хаалга (web shell)-ээр дамжуулан удирдахтай холбоотой)

T1072 – Програм хангамж түгээх хэрэгслүүд (Халдагч этгээд Secure Socket Funnelling (SSF) гэх үнэгүй хэрэгслийг ашиглан IP хаяг руу холбогдсон үйлдэлтэй холбоотой)

Тогтвортой нэвтрэлт (Persistence)

T1505.003 – Серверийн програм хангамжийн бүрдэл хэсэг: Арын хаалга (Web Shell) (Халдагч этгээд арын хаалга болон SSF ашиглан сүлжээнд дахин нэвтрэх тогтвортой хандалт тогтоосон үйлдэлтэй холбоотой)

Нэвтрэх мэдээлэл хулгайлах

T1552.001 – Нууц үг хадгалах сангаас мэдээлэл хулгайлах (Барилгын удирдлагын систем (BMS)-тэй холбоотой нууц үг хадгалагдсан файлуудтай холбоотой)

T1558.003 – Керберос код хулгайлах эсвэл хуурамчаар үйлдэх: Керберос ашиглан халдах (Сүлжээний нэвтрэх эрх олж авах зорилгоор Керберос халдлагыг хийсэнтэй холбоотой)

Хөндлөн шилжилт

T1021.002 – Зайнаас хандах үйлчилгээ: SMB хуваалтууд (Халдагч этгээд олон төхөөрөмжөөс SMB хуваалтуудыг холбосон үйлдэлтэй холбоотой)

Цуглуулалт

T1213 – Мэдээллийн агуулахуудаас мэдээлэл авах (BMS сервер дээрх гарын авлага, техникийн баримт бичгүүдтэй холбоотой)

Мэдээлэл хууль бусаар зөөвөрлөх

T1041 – Команд ба хяналтын сувгаар мэдээлэл алдагдуулах (Exfiltration Over C2 Channel) (Active Directory болон холбосон сүлжээний хуваалтуудаас өгөгдөл алдагдсан үйл ажиллагаатай холбоотой)

Жишиг судалгаа 2

Энэхүү тайланг олон нийтэд өргөн хүрээнд түгээх зорилгоор нэрийг нууцалсан болно. Халдлагад өртсөн байгууллагыг цаашид "байгууллага" гэж нэрлэнэ. Хохирогч байгууллагын үнэн зөв байдлыг хадгалах болон ASD-ийн ACSC-гийн хариу арга хэмжээний аргачлалыг хамгаалах үүднээс тодорхой мэдээллийг хассан болно.

Товч хураангуй

Энэхүү тайлан нь 2022 оны 4-р сард байгууллагын сүлжээнд амжилттай нэвтэрсэн халдлагын талаар ASD-ийн Цахим Аюулгүй Байдлын Төв (ACSC)-ийн явуулсан мөрдөн шалгалтын үр дүнг нэгтгэсэн болно. Мөрдөн шалгалтын энэхүү тайланг тухайн байгууллагад хүргүүлсэн бөгөөд илэрсэн халдлагын үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж, хамгаалалт, сэргээлтийн зөвлөмжийг хүргэсэн болно. Мөрдөн шалгалтын үр дүнд энэхүү халдлагыг APT40 бүлэглэл үйлдсэн болохыг тогтоосон.

2022 оны тавдугаар сард ASD-ийн Цахим Аюулгүй Байдлын Төв (ACSC) нэгэн байгууллагад хандан тэдний сүлжээнд 2022 оны дөрөвдүгээр сараас хойш халдлагууд ажиглагдсан талаар анхааруулсан. Үүний дараагаар тус байгууллага нь интернэтэд холбогдсон нэгэн сервер дээрээ сэжиг бүхий хортой программ илрүүлсэн тухай ACSC-д мэдэгдсэн бөгөөд уг сервер нь байгууллагын албан хэрэгцээний зайнаас хандалтын системийн нэвтрэх порталаар ашиглагдаж байсан. Энэ сервер нь зайнаас нэвтрэх эрх болон хэрэглэгчийн таних мэдээлэл удирдах зориулалттай бүтээгдэхүүн агуулж байсан бөгөөд энэхүү тайланд “зөвшөөрөлгүй нэвтэрсэн төхөөрөмж” (the compromised appliance) хэмээн нэрлэгдэх болно. Энэхүү тайланд ASD-ийн ACSC-аас явуулсан мөрдөн шалгалтын үр дүн, мөн тухайн байгууллагад зориулан боловсруулсан сэргээх арга хэмжээний зөвлөмжүүдийг тусгасан болно.

Шалгалтаар тухайн байгууллагын сүлжээний нэг хэсэг нь 2022 оны дөрөвдүгээр сараас хойш зайнаас хандах портал-аар дамжуулан цахим халдагчдын гарт орсон болох нь тогтоогдсон. Мөн уг сервер нь тухайн үеийн олон нийтэд ил болсон Remote Code Execution (RCE) төрлийн сул талыг ашигласан байх магадлалтай бөгөөд ганц биш, хэд хэдэн халдагчийн зүгээс нэвтрэлт хийсэн байх боломжтой.

ASD-ийн ACSC-гийн баг дараах гол үйл ажиллагааг илрүүлсэн:

- Хост тандах (Host Enumeration) – Халдагч тал байгууллагын сүлжээний бүтцийн зураглал үүсгэдэг..
- Интернэтэд нээлттэй програм, веб апликэйшнийг ашиглан нэвтрэх болон арын хаалга (websshell) ашиглах. Энэ нь халдагч талд сүлжээнд анхлан нэвтрэх, удирдлагыг алсаас илгээх боломжийг олгодог.
- Програм хангамжийн сул талыг ашиглан нэвтрэх эрх нэмэгдүүлэх,
- мөн сүлжээнд дотоод шилжилт хийхэд шаардлагатай нэвтрэх бүртгэлийн мэдээлэл цуглуулах зэрэг үйлдлүүд хийгдсэн байв.

ASD-ийн Цахим Аюулгүй Байдлын Төв (ACSC)-ийн шалгалтаар 2022 оны дөрөвдүгээр сард зөвшөөрөлгүй хандсан төхөөрөмж дээрээс хэдэн зуун өвөрмөц хэрэглэгчдийн нэр, нууц үг зөөвөрлөгдсөн нь тогтоогдсон. Түүнчлэн зайнаас хандахад шаардлагатай давхар баталгаажуулалтын код алдагдсан байж болох ул мөрүүд олдсон байна. Байгууллагын дотоод хяналт, шалгалтаар эдгээр нууц үгс нь хүчинтэй, бодит хэрэглэгчидтэй холбоотой болох нь батлагдсан. ASD-ийн ACSC-ийн дүгнэж буйгаар, уг халдагч эдгээр цахим мэдээллийг ашиглан жинхэнэ хэрэглэгчийн нэрийн өмнөөс зайнаас нэвтрэлт хийх, улмаар байгууллагын дотоод сүлжээнд хууль бус байдлаар хандах зорилготой байсан байх өндөр магадлалтай.

Мөрдөн шалгалтын дүн

Мөрдөн шалгалтын тойм

ASD-ийн Цахим Аюулгүй Байдлын Төв (ACSC)-ийн үнэлгээгээр цахим халдагч нь байгууллагын ажилтнуудын зайнаас нэвтрэх төхөөрөмжүүд рүү халдаж, улмаар түүгээр дамжуулан нэмэлт сэжигтэй үйл ажиллагаа явуулахыг оролдсон байна. Эдгээр төхөөрөмж нь хоорондоо ачаалал тэнцвэржүүлэгчтэй гурван хостуудаас бүрддэг бөгөөд хамгийн эхний халдлагын ул мөр гурван хост дээр илэрсэн. Халдлагын анхны шинж тэмдгүүд илэрсний дараахан байгууллага хоёр хостыг унтраасан. Үүний улмаас дараагийн бүх сэжигтэй үйлдлүүд үлдсэн ганц хост дээр явагдсан байна. Халдлагад өртсөн төхөөрөмжтэй холбоотой бусад серверүүд ч мөн ачаалал тэнцвэржүүлэгчтэй бүтэцтэй байсан. Илүү ойлгомжтой болгохын тулд, тайлангийн ихэнх хэсэгт эдгээр төхөөрөмжүүдийг "нэг төхөөрөмж" гэж нэрлэсэн болно.

Халдагч этгээдүүд нь 2022 оны дөрөвдүгээр сараас эхлэн олон нийтэд ил болсон сул байдлыг ашиглан уг төхөөрөмж дээр арын хаалга (webshell) байршуулсан гэж үзэж байна. Мөн халдагч нь уг төхөөрөмж дээр нэвтрэх эрх нэмэгдүүлэлт хийж, хяналт тогтоосон гэж дүгнэгджээ. ASD-ийн ACSC нь лог бүртгэл хязгаарлагдмал байсан тул халдлагын цар хүрээг бүрэн тодорхойлж чадаагүй. Гэсэн хэдий ч төхөөрөмж дээрх нотолгооноос харахад дараах үйлдлүүд хийгдсэн нь тогтоогдсон:

- Хэдэн зуун бодит хэрэглэгчийн нэр, нууц үгийн хослосон мэдээллийг цуглуулсан;
- Мөн тус төхөөрөмжөөс хортой этгээдүүд виртуал десктоп дэд бүтцийн (VDI) хандалтад жинхэнэ хэрэглэгчийн нэрээр нэвтрэх боломж олгох цахим мэдээлэл цуглуулсан нь тогтоогдсон.

ASD-ийн Цахим Аюулгүй Байдлын Төв (ACSC)-ийн үнэлгээгээр, халдагч этгээдүүд байгууллагын сүлжээнд цааш халдах, илүү гүнзгий хяналт тогтоох зорилготой байсан байх магадлалтай. Халдагчийн гадагш зөөвөрлөсөн эдгээр мэдээлэлэ нь тухайн этгээдийг өөрийн сонгосон жинхэнэ хэрэглэгчийн эрхээр буюу удирдлагын эрхтэй хэрэглэгчийн нэрээр VDI хандалт рүү хууль бусаар нэвтрэх, эсвэл хандалт эхлүүлэх боломжийг олгосон байж болзошгүй. Энэ төрлийн нэвтрэлтийг ашиглан халдагч этгээд байгууллагын дотоод үйлчилгээ, системийг илүү өргөн хүрээтэй хянах, тогтвортой нэвтрэх эрх (persistence) бий болгох, бусад зорилгоор ашигласан байх магадлалтай.

Тухайн төхөөрөмжийн хостинг үйлчилгээ үзүүлэгч бусад ижил төстэй төхөөрөмжүүд дээр халдлагын ул мөр илрээгүй болно.

Хандалт

Халдлагад өртсөн төхөөрөмжийн хост нь хэрэглэгч VDI (Виртуал Десктоп Дэд бүтэц) хандалтрүү холбогдох үед Active Directory болон вэб серверээр дамжуулан баталгаажуулалт хийдэг байсан (T1021.001).

Байршил	Халдлагад өртсөн төхөөрөмжүүдийн хост нэрс (ачаалал тэнцвэржүүлсэн):
Дата төв 1	HOST1, HOST2, HOST3

Халдлагад өртсөн төхөөрөмжийн дэд бүтэц нь хэрэглэгч баталгаажуулалтын токен хүлээн авсны дараа Виртуал Десктоп Дэд бүтэц (VDI)-д холбогдох туннел (суваг) үүсгэдэг хандалтын гарц хостууд (access gateway hosts)-ыг мөн агуулж байсан.

Эдгээр хандалтын гарц хостууд халдлагад өртсөн гэсэн шууд нотолгоо олдоогүй. Гэсэн хэдий ч, эдгээр хостуудын мэдээллийн бүртгэлд сэжигтэй, хортой үйл ажиллагаанд холбогдож байсан IP хаягуудтай их хэмжээний холбоо тогтоосон байсныг харуулсан ул мөр илэрсэн. Энэ нь уг хост дээр шууд үйлдэл хийгдсэн эсвэл тухайн хост руу гадны заналхийлэгчийн дэд бүтэцтэй холбогдсон сүлжээний харилцаа үүссэн байх боломжтойг илтгэнэ. Одоогоор байгаа нотолгоонд тулгуурлан үйл ажиллагааны нарийн шинж чанарыг бүрэн тогтоох боломжгүй байгаа боловч, уг бүлэглэл нь байгууллагын сүлжээгээр шилжих (lateral movement) оролдлого хийж байсныг харуулж байна (TA0008).

Дотоод хостууд

ASD-ийн Цахим Аюулгүй Байдлын Төв (ACSC) нь тус байгууллагын дотоод сүлжээний сегментээс бага хэмжээний мэдээлэл авч, шинжилгээ хийсэн. Байгууллагын дотоод сүлжээний сегментэд нөлөөлсөн буюу нөлөөлөхийг оролдсон халдлагын мэдэгдэж буй үйлдлүүдэд дараах зүйлс багтана. Үүнд: VDI-тэй холбоотой баталгаажуулалтын өгөгдөлд хандах; байгууллагын дотоод SQL серверээс мэдээлэл хуулж авах үйлдэл (T1505.001); мөн мэдэгдэж буй хортой IP хаягуудаас гарсан сэжигтэй сүлжээний урсгал нь хандалтын гарц төхөөрөмж (access gateway appliance)–аар дамжин өнгөрсөн байна (TA0011).

Цахим гэмт этгээдүүд төхөөрөмжид хандах боломжоор дамжуулан жинхэнэ хэрэглэгчийн нэр, нууц үг (T1003), олон үе шаттай баталгаажуулалтын (MFA) код (T1111) цуглуулсан байна. Мөн виртуал десктоп хандалт үүсгэхэд хэрэглэгддэг JSON Web Token (JWT) зэрэг баталгаажуулалтын мэдээлэл цуглуулсан байна (T1528). Цуглуулсан эдгээр мэдээллийг ашиглан виртуал десктоп орчныг хууль ёсны хэрэглэгчийн нэрээр үүсгэх

эсвэл булаан авах (T1563.002) замаар байгууллагын дотоод сүлжээнд хууль ёсны эрхтэй мэт хандах (T1078) боломжтой болсон байж болзошгүй.

Мөн уг төхөөрөмжөөр дамжуулан байгууллагын дотоод сүлжээнд байрлах SQL серверээс мэдээлэл татах буюу "scrape" хийх ажиллагаа гүйцэтгэсэн нь тогтоогдсон (T1505.001). Энэхүү өгөгдөлд халдагч этгээд нэвтрэх эрхтэй байсан байх магадлалтай.

Нэвтрэх гарцын төхөөрөмжөөс олдсон нотолгоо нь хортой IP хаягууд энэ төхөөрөмжөөр дамжин сүлжээний урсгал явагдсан болохыг харуулж байна. Дээр дурдсанчлан, энэ нь цахим гэмт этгээдүүд тус төхөөрөмжид нөлөөлсөн буюу халдсан байж магадгүй бөгөөд үүний тусламжтайгаар дотоод сүлжээнд нэвтрэхийг оролдсон байж магадгүйг харуулж байна.

Шалгалтын үйл явцын цаг хугацааны дараалал

Доорх жагсаалт нь шалгалтын явцад илрүүлсэн гол үйл ажиллагааны цаг хугацааны дарааллыг харуулна.

Цаг	Үйл явдал
2022 оны 4-р сар	Халдлага үйлдэгчтэй холбогдсон нэр бүхий хортой IP хаягууд HOST7 сервертэй харилцсан. Эдгээр холболтын нарийн шинж чанарыг тодорхойлох боломжгүй байв.
2022 оны 4-р сар	HOST1, HOST2 болон HOST3 бүх серверүүд халдлагад өртсөн бөгөөд дээрх серверүүд дээр арын хаалга (webshell) байрлуулсан. HOST2 дээр бүртгэлийн лог файлууд үүсгэгдсэн эсвэл засварлагдсан. Тухайн файлд хэрэглэгчийн нэр, нууц үгийн мэдээлэл агуулагдаж байх магадлалтай. HOST1 болон HOST3 серверүүд дээрх “/etc/security/opasswd” болон “/etc/shadow” системийн файлууд өөрчлөгдсөн нь нууц үг солигдсоныг илтгэж байна Мөн HOST1 дээрх нотолгооноос үзэхэд “sshuser” хэрэглэгчийн нууц үг өөрчлөгдсөн байна.
2022 оны 4-р сар	HOST2-ыг байгууллага унтраасан. HOST1 болон HOST3 дээр нэмэлт арын хаалгууд (webshell) (T1505.003) үүссэн. HOST3-аас HOST1 руу SSH нэвтрэх эрхийн халдлагын оролдлогууд илэрсэн. HOST3 дээр бүртгэлийн лог файл засварлагдсан (T1070). Энэхүү файлд магадгүй халдагч этгээдийн авсан хэрэглэгчийн нэр, нууц үгийн мэдээлэл (T1078) агуулагдаж байна. JWT-ууд цуглуулж, HOST3 дээр хадгалагдсан байна (T1528). HOST3-ыг байгууллага унтраасан. Үүний дараах бүх үйл ажиллагаа HOST1 дээр явагдсан.
2022 оны 4-р сар	HOST1 дээр нэмэлт арын хаалгууд (webshell) үүссэн (T1505.003). JWT-үүдийг цуглуулж, HOST1 дээр файл гаргасан.
2022 оны 4-р сар	HOST1 дээр нэмэлт арын хаалгууд (webshell) үүссэн (T1505.003) ба хортой IP хаяг уг сервертэй холбогдсон (TA0011). Хортой IP хаяг ACCESS GATEWAY-ийн HOST7 сервертэй холбогдсон.
2022 оны 5-р сар	Хортой IP хаяг ACCESS GATEWAY-ийн HOST7 сервертэй холбогдсон (TA0011). HOST1 дээрх бүртгэлд хэрэглэгчийн нэвтрэлт нь хортой IP хаягтай холбогдсон. Энэхүү сервер дээр нэмэлт арын хаалга (webshell) үүссэн (T1505.003).
2022 оны 5-р сар	Халдагч этгээдийн үйлдлээр HOST1 дээрх скрипт өөрчлөгдсөн (T1543). Энэхүү скрипт нь дотоод SQL серверээс өгөгдөл авдаг функцтэй байжээ.
2022 оны 5-р сар	HOST1 дээр нэмэлт бүртгэлийн лог файл сүүлд засварлагдсан (T1070). Энэхүү файлд байгууллагын сүлжээнд ашиглагдсан хэрэглэгчийн нэр, нууц үг байгаа бөгөөд тэдгээр нь жинхэнэ хаягуудын нэвтрэх эрхийн мэдээлэл гэж үзэж байна (T1078).
2022 оны 5-р сар	Нэмэлт бүртгэлийн лог файл сүүлд засварлагдсан (T1070). Энэ файлд HOST1-ээс цуглуулсан JWT-үүд агуулагдаж байна.
2022 оны 5-р сар	HOST1 дээр нэмэлт арын хаалгууд (webshell) үүссэн (T1505.003). Энэ өдөр байгууллага 2022 оны 4-р сард үүсгэсэн арын хаалга (webshell) олдсоныг ASD-ийн ACSC-д мэдээлсэн.
2022 оны 5-р сар	HOST1 дээр хэд хэдэн скрипт үүссэн, түүний дотор Log4jHotPatch.jar нэртэй файл орсон.
2022 оны 5-р сар	iptables-save командыг ашиглан ACCESS GATEWAY-ийн серверт 2 нээлттэй порт нэмсэн. Эдгээр портууд нь 9998 ба 9999 байв (T1572).

Цахим халдагчийн тактик, техникийг онцолсон хэсэг

Шалгалтын явцад илэрсэн хэд хэдэн арга техникүүдийг доор дурдсан байна.

Эхний нэвтрэлт

T1190 Интернэтэд холбогдсон аппликейшний сул талыг ашиглах

Халдлагын бүлэг нь зайнаас хандалт болон таних удирдлагын системүүдийн алсын код гүйцэтгэх (RCE), нэвтрэх эрх нэмэгдүүлэх, баталгаажуулалтыг алгасах, тойрох зэрэг эмзэг байдлыг ашиглан байгууллагын сүлжээнд анхны нэвтрэлтийг хийсэн байх өндөр магадлалтай гэж үзэж байна.

Энэхүү анхны нэвтрэх аргыг хамгийн магадлалтай гэж үзэж байгаа нь дараахтай холбоотой:

- Халдлага үйлдэгдсэн тухайн үед сервер нь нийтэд танигдсан CVE-үүдэд өртөмтгий байсан;
- Нэр бүхий халдагч этгээдийн хяналттай дэд бүтцээс эдгээр сул талыг ашиглах оролдлогууд хийсэн нь бүртгэгдсэн;
- Эдгээр оролдлогын дараахан дотоод сүлжээнд анхны халдлагын үйлдлүүд илэрсэн.

Гүйцэтгэл

T1059.004 Command and Scripting Interpreter програм: Юникс арын хаалга (Unix webshell)

Халдлагын бүлэг дээр дурдсан сул талуудыг амжилттай ашигласнаар, халдварласан төхөөрөмж дээрх Юникс арын хаалгаар дамжуулан командыг гүйцэтгэх боломжтой болсон байх магадлалтай. Төхөөрөмж дээрх бүртгэлийн бүрэн бус байдал нь халдагч этгээдүүдийн гүйцэтгэсэн командуудыг бүрэн тодорхойлоход хүндрэл учруулж байна.

Тогтвортой нэвтрэх

T1505.003 Серверийн Программ Хангамжийн Бүрэлдэхүүн Хэсэг: Арын хаалга (webshell)

Халдагч этгээдүүд нэвтэрсэн төхөөрөмжид хэд хэдэн арын хаалга (webshell) байршуулсан. Мөн энэ хугацаанд өөр өөр бүлэглэлүүд арын хаалгуудыг (webshell) байршуулсан байх магадлалтай боловч зөвхөн цөөн тооны бүлэглэл эдгээрийг идэвхтэй ашигласан байх үндэслэлтэй байна. Арын хаалгууд (webshell) нь халдагч этгээдэд төхөөрөмж дээр дурын командыг гүйцэтгэх боломжийг олгосон.

Нэвтрэх эрхийн нэмэгдүүлэлт

T1068 Нэвтрэх эрх нэмэгдүүлэх зорилгоор сул талуудыг ашиглах

Халдагч этгээдүүдийн ямар түвшний удирдлагын эрхтэй байсныг бүрэн тодорхойлох боломжгүй Гэсэн хэдий ч арын хаалга ашигласнаар тэдгээр нь веб серверийн хэрэглэгчийн эрхтэй дүйцэхүйц түвшинд команд гүйцэтгэх боломжтой болсон гэж дүгнэж байна. Халдлагад өртсөн төхөөрөмжийн сул талуудыг ашиглан халдагч этгээдүүд гол нэвтрэх эрхийг олж авсан байх боломжтой гэж үзэж байна.

Нэвтрэх мэдээлэл хулгайлах

T1056.003 Оруулах өгөгдөл хулгайлах: Веб портал эзлэх

Халдсан төхөөрөмжөөс олдсон нотолгооноос харахад, халдагч этгээд хэдэн зуун тооны хэрэглэгчийн нэр болон нууц үгийн хослолыг текст бичгэн хэлбэрээр гарган авсан байна. Эдгээр мэдээллүүд нь жинхэнэ хэрэглэгчдийнх байх магадлалтай. Эдгээр мэдээллүүдийг бодит баталгаажуулалтын процессыг өөрчилж, нэвтрэх эрхийн мэдээллийг файл руу хадгалах замаар хураан авсан гэж үзэж байна.

T1111 Давхар баталгаажуулалтын мэдээллийг олзлох

